

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/263

Сүхбаатар сум

Г Үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх  
ажлыг зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.3, 6.5 заалт, Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 69 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт Сэлэнгэ мөрөн, Орхон голын сав газруудад үүссэн үерийн гамшгийн нөхцөл байдалтай уялдуулан хүн, мал, иргэдийг авран хамгаалах төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулсугай.

2. Иргэдийг болзошгүй гол, усны ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хамгаалах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Г.Галбадрах/-д үүрэг болгосугай.

3. Гол, мөрний усны түвшний хэмжилтийн талаарх мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 10:00 цагт аймгийн Онцгой байдлын газарт мэдээлж ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Энх-Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.


4. Сум орон нутгийн түвшинд үерийн далан суваг, шуудууг цэвэрлэх, хүчитгэх, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Гол, усны ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хамгаалах үйл ажиллагаанд ашиглах моторт завины шинэ мотор худалдан авахад шаардлагатай 6,000,000 /зургаан сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж аймгийн

430810641

Онцгой байдлын газарт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ОРГИЛ

